

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН**

(2023 он)

Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо
1	2	3	4	5
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	91.1	0.6	4.61
	2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	87.2	53.5	
	3. Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт	-		
	4. Салбарын хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	-		
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	96.1	0.2	
	2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	95.7	19.2	
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	99.4	0.2	
	2. Шилэн дансны хөтөлөлтийн үнэлгээ	90	19.5	
	3. Шударга байдлын түвшний үнэлгээ	100		
	4. Хэрэглэгчийн үнэлгээ	100		
<b>Ерөнхий үнэлгээ:</b>		<b>92,2</b>	1.0	

-----o0o-----

## СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 27

Улаанбаатар хот

### Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Стандарт хэмжил зүйн газрын хяналтад байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, чиг үүргийн нээлттэй байдлын үзүүлэлтүүдэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх, гарсан зөвлөмжийг дараагийн төлөвлөлтөд тусгах, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг нэмэгдүүлэх, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

### Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам, Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2022 оны А/99 дүгээр тушаалаар батлагдсан Стандарт, хэмжил зүйн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журмыг үндэслэн Стандарт, хэмжил зүйн газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Үйл ажиллагааны үр дүнг үнэлэхэд Стандарт, хэмжил зүйн газрын хяналтад авсан дараах баримт бичгийн хэрэгжилтийн тайланг болон аймгуудын Стандарт, хэмжил зүйн үйл ажиллагааны тайланг хамруулсан. Үүнд:

#### а. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж:

- 3.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт;
- 3.2. “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилт;
- 3.3. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт;
- 3.4. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт;

#### б. Байгууллын чиг үүргийн үзүүлэлт:

- 3.5. Стандарт, хэмжил зүйн газрын Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2023 оны биелэлт;
- 3.6. Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2022 оны А/102 дугаар тушаалаар батлагдсан Стандарт, хэмжил зүйн салбарын албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт;

#### в. Байгууллагын нээлттэй байдлын үзүүлэлт:

- 3.7. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ;
- 3.8. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ;
- 3.9. Шударга байдлын түвшний үнэлгээ;
- 3.10. Хэрэглэгчийн үнэлгээ;

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 6.2, 6.3-т заасан арга зүйгээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ тайлангаас гадна албан хаагчдаас нэмэлт тодруулга авах, хамааралтай баримт бичиг, статистик тоон мэдээлэл, хэрэглэгчийн судалгааны дүн, өмнөх хяналт-шинжилгээний зөвлөмжийн хэрэгжилт зэргийг харгалзан, дүн шинжилгээ хийсэн.

Журамд заасны дагуу нэгдсэн үнэлгээг тооцсон ба шилэн дансны хөтлөлтийг shilendans.gov.mn сайт, Хэрэглэгчийн үнэлгээг зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн хэрэглэгч, сонирхогч талуудаас авсан Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны дүгнэлтийг тус тус ашигласан.

## Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

### А. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ:

#### 3.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт:

2023 оны Засгийн газрын хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ үнэлгээний нэгдсэн цахим (*unelgee.gov.mn*) хуудсанд нийт 32 хууль тогтоомжийн 90 заалтыг байршуулсан байна. Үүнд:

- ✓ Монгол улсын 6 хуулийн 55 заалт;
- ✓ Монгол Улсын Их хурлын 6 тогтоолын 9 заалт;
- ✓ Монгол Улсын Их хурлын Байнгын хорооны 2 тогтоолын 3 заалт;
- ✓ Ерөнхийлөгчийн 4 зарлигийн 6 заалт;
- ✓ Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 1 тогтоолын 1 заалт;
- ✓ Монгол Улсын Засгийн газрын 5 тогтоолын 5 заалт;
- ✓ Монгол Улсын Засгийн газрын хуралдааны 6 тэмдэглэлийн 10 заалт;
- ✓ Монгол Улсын Засгийн газрын 1 албан даалгаврын 1 заалт
- ✓ Ерөнхий сайдын 1 захирамжийн 1 заалт;

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланд хийсэн үнэлгээг хүснэгтээр харуулбал:

№	Нэр	Хууль тогтоомжийн	Заалтын тоо	Хэрэгжилт (хувиар)					Хяналтаас хасуулах санал		Хэрэгжилт хувиар
				100	70	30	Хугацаа болоогүй	Чиг үүрэгт хамаарахгүй	Тоо	Заалтын дугаар	
1	Монгол Улсын хууль	6	55	51	4	-	-	-	9	Хэмжил зүйн тухай хууль-3, 4, 5, 6, 7, 8, 9, 11, 41(8.4.27),	97.8
2	Улсын Их Хурлын тогтоол	6	9	7	2	-	-	-	3	62(1.2), 63(2.3), 64(2.5)	93.3
3	УИХ-ын Байнгын хорооны тогтоол	2	2	1	1	-	-	-	1	66(6г), 67	85.0
4	Ерөнхийлөгчийн зарлиг	4	6	6	-	-	-	-		72, 73	100
5	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж	1	1	1	-	-	-	-			100
6	МУЗГ-ын тогтоол	5	5	4	-	1	-	-			86,0
7	МУЗГ-ын хуралдааны тэмдэглэл	6	10	6	4	-	-	-			88,0
8	МУЗГ-ын албан даалгавар	1	1	1	-	-	-	-			100

9	Ерөнхий сайдын захирамж	1	1	-	1	-	-	-		70
	<b>Нийт</b>	<b>32</b>	<b>90</b>	<b>77</b>	<b>12</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>13</b>	
	<b>Хэрэгжилтийн ерөнхий дүн</b>									<b>91,1</b>

Бүрэн хэрэгжсэн 77 заалт, хэрэгжих шатанд 12 заалт, хэрэгжилт хангалтгүй 1 заалт байгаа бөгөөд хэрэгжилтийн ерөнхий дүн 91.12% байна.

Хэрэгжилт удаашралтай буюу хэрэгжих шатанд буй доорх арга хэмжээг анхаарах. Үүнд.

№	Хяналтад буй заалт	Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
1	Хэмжил зүйн тухай 7.7.Энэ хуулийн 7.6-д заасан техникийн зохицуулалтыг Засгийн газар батална. (7.6.Энэ хуулийн 8.1-д заасан үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгсэлд тавих тусгай шаардлагыг техникийн зохицуулалтаар тогтооно.)	Засгийн газрын хуралдааны 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 48 дугаар тэмдэглэлд "Шаардлагатай техникийн зохицуулалтыг батлах"-аар тусгагдсаны дагуу Цахилгааны тоолуурын техникийн зохицуулалт боловсруулах талаар Эрчим хүчний яамны холбогдох ахлах мэргэжилтнүүдэд мэдээлэл өгч, санал солилцсон ба төсөлд нэмэлт өөрчлөлт оруулан хамтран ажилласан. Цахилгааны тоолуурын техникийн зохицуулалтын төслийг боловсруулах талаар "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК, "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК-ийн инженер, техникийн ажилтнуудад ОУ-ын төсөл, уулзалт, сургалт, семинарын хүрээнд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Эрчим хүчний яамны дэргэд байгуулагдсан ажлын хэсэгтэй хамтран "Цахилгааны тоолуурын техникийн зохицуулалт"-ын төслийг эцэслэн боловсруулж, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг нэгтгэн 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 05/1119 дугаар албан бичгээр ЭХЯ-д хүргүүлсэн.	70
2	Хэмжил зүйн тухай хууль 23.4.Хэмжил зүйн ажил, үйлчилгээний төлбөрийн хэмжээг хэмжил зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Стандарт, хэмжил зүйн газрын баталгаажуулалтын ажил, үйлчилгээ, Хэмжил зүйн салбарын ажил үйлчилгээ, Үнэт металлын сорьц тогтоох, эрдэнийн чулуу тодорхойлох ажил үйлчилгээ, Лабораторийн шинжилгээ хийх ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоох аргачлалыг Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 67 дугаар "Ажил, үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоох аргачлал" тушаалаар шинэчлэн баталсан. Хэмжил зүйн дараах 5 ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоохоор шаардлагатай коэффициентуудыг гарган батлагдсан аргачлалын дагуу хэмжил зүйн ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох хэлэлцүүлгийн ажлыг зохион байгуулж, батлуулахаар ажлын хэсэгт хүргүүлсэн. Үүнд: Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалт; Хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга; Хэмжих хэрэгслийн загварыг турших, батлах; Хэмжих хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, суурилуулах, засварлах ААНБ-ын чадавхыг үнэлэх;	70

		Хэмжил зүйн мэргэжлийн байгууллагын чадавхыг үнэлэх;	
3	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021-12-17 Дугаар 2022.05.01 8.2.9. хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл;	Сорьцын хяналт, Бүтээгдэхүүний баталгаажуулалт, Баталгаажуулсан хэмжих хэрэгсэл, шинжлүүлсэн дээжийн тоо зэрэг статистик мэдээллийг Стандарт, хэмжил зүйн газрын <a href="http://www.masm.gov.mn">www.masm.gov.mn</a> цахим хуудасны статистик мэдээлэл цэсэд нээлттэй байршуулсан.	70
4	Хөрөнгийн үнэлгээний тухай хууль 4.5. Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хөрөнгийн үнэлгээний үндэсний стандартыг үнэлгээний олон улсын стандартын зарчим болон энэ хуульд нийцүүлэн батална.	Хөрөнгийн үнэлгээний үндэсний стандартыг боловсруулан ирүүлэх тухай Стандарт, хэмжил зүйн газрын 2023 03 сарын 02-ны өдрийн 01/155 дугаартай албан бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсэн. Тус хорооноос 2023 оны 03 сарын 15-ны өдрийн 3/1028 дугаартай албан бичгээр дээрх стандартыг Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулах талаар хариу ирүүлсэн. Сангийн яаманд Хөрөнгийн үнэлгээний үндэсний стандартыг боловсруулан ирүүлэх тухай хүсэлтийг хүргүүлэхээр төлөвлөсөн.	70
5	Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай 4. Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн биелэлтийг зохион байгуулж, хэрэгжилтийн тайланг жил бүрийн намрын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хуралд хүргүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.	Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлого, хэрэгжилтийн асуудлыг олон улсын түвшинд хүргэх асуудлыг судлан үзэж, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулан танилцуулах ажлын хэсгийг Ерөнхий сайдын 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 159 дүгээр захирамжаар байгуулагдсан. Тус ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх зорилго бүхий ажлын Дэд хэсэг Монгол Улсын Шадар сайдын 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 80 дугаар тушаалаар байгуулагдсан бөгөөд ажлын дэд хэсгийн гишүүд салбар салбартаа Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн, саналыг нэгтгэсэн. Мөн Стандарт, хэмжил зүйн газраас 21 аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсээрээ дамжуулан иргэд, олон нийтээс санал авах үйл ажиллагааг зохион байгуулж, саналыг нэгтгэн боловсруулж Хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл болон хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Шадар сайдад 2 удаа танилцуулсан.	70
6	4. Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн биелэлтийг зохион байгуулж, хэрэгжилтийн тайланг жил бүрийн намрын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хуралд хүргүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.	Стандарт, хэмжил зүйн газраас Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу боловсруулан Монгол Улсын Шадар сайдад 2 удаа танилцуулсан. Эцсийн дүгнэлт хийлгэхээр гэрээ байгуулан ажиллаж байна. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд 2024 онд өргөн барихаар төлөвлөсөн.	70

7	<p>Чиглэл өгөх тухай 2023-03-28 Дугаар 2023№05 НББХ</p> <p>1.1.3/. хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхдийн сэтгэл санааны гэм хорыг үнэлэх, тооцох аргачлалыг яаралтай боловсруулах, хохирогчийн нийгэм, сэтгэл зүйн нөхөн сэргээх үйлчилгээнд үзүүлэх стандартыг тогтоох, хэрэгжүүлж ажиллах;</p>	<p>Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулан ирүүлсэн MNS .....:2023, Насанд хүрээгүй гэрч, хохирогчийг хамгаалах нийтлэг шаардлага” стандартын төсөлд 8 байгууллагаас санал авч, ирүүлсэн саналыг Стандарт, хэмжил зүйн газрын 2023 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн 01/1028 тоот албан бичгийн хамт Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Тус яам нь саналыг тусгах, сайжруулах ажлыг хийж байна.</p>	70
8	<p>Нийслэлийн цэцэрлэгийн хүртээмжийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай</p> <p>5. Гэр цэцэрлэг болон орон сууцны 1 дүгээр давхарт үйл ажиллагаа явуулах цэцэрлэгийн орчинд тавигдах стандарт нөхцөл, шаардлагыг боловсруулах, хүүхдийн эрүүл, аюулгүй байдал холбогдох бусад шаардлагыг бүрэн хангасан стандарт батлан мөрдүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Стандарт, хэмжил зүйн газар (Б.Билгүүн), Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Б.Баасандорж) нарт тус тус даалгасугай.</p>	<p>Боловсрол, шинжлэх ухааны сайдад Гэр цэцэрлэг болон орон сууцны 1 дүгээр давхарт үйл ажиллагаа явуулах цэцэрлэгийн орчинд тавих стандарт нөхцөл, шаардлагыг тогтоосон стандартын төслийг боловсруулан ирүүлэхийг хүссэн 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 01/902 дугаартай албан бичиг хүргүүлсэн. Тус яамнаас 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 13/5937 дугаартай албан бичгээр дээрх стандартын төслийг боловсруулж байгаа талаарх мэдээллийг ирүүлсэн.</p> <p>Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 01/393 дугаартай албан бичгээр дээрх стандартын төслийг боловсруулж ирүүлэхийг хүссэн албан бичгийг дахин явуулсан.</p> <p>Стандартын төсөл боловсруулагдан ирүүлсний дараа Стандарт, хэмжил зүйн газраас төслийг холбогдох стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлэх, шийдвэр гаргуулах ажлыг зохион байгуулна.</p>	30
9	<p>Ажлын хэсэг байгуулах тухай</p> <p>2. Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлого, хэрэгжилтийн асуудлыг олон улсын түвшинд хүргэх боломжийг судлан үзэж, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулан танилцуулах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай: Хуулийн төслийг эцэслэн боловсруулж 2022 оны 11 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Ажлын хэсэг (С.Амарсайхан)-т даалгасугай.</p>	<p>Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлого, хэрэгжилтийн асуудлыг олон улсын түвшинд хүргэх асуудлыг судлан үзэж, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулан танилцуулах ажлын хэсгийг Ерөнхий сайдын 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 159 дүгээр захирамжаар байгуулагдсан.</p> <p>Тус ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх зорилго бүхий ажлын Дэд хэсэг Монгол Улсын Шадар сайдын 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 80 дугаар тушаалаар байгуулагдсан бөгөөд ажлын дэд хэсгийн гишүүд салбар салбартаа Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн, саналыг нэгтгэсэн.</p> <p>Мөн Стандарт, хэмжил зүйн газраас 21 аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсээрээ дамжуулан иргэд, олон нийтээс санал авах үйл ажиллагааг зохион байгуулж, саналыг нэгтгэн боловсруулж Хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл болон</p>	70

		хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Шадар сайдад 2 удаа танилцуулсан.	
10	2022 оны 2 дугаар сарын 16-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл XIX.6.2. "Шинэ сэргэлтийн бодлого"-д тусгагдсан Төрийн бүтээмжийг сайжруулах шинэчлэлтийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх шаардлагыг тогтоох, байгууллага, албан тушаалтан иргэнтэй шууд харьцах замаар үйлчилгээ үзүүлдэг байдлыг халах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагад даалгав.	<p>Стандарт, хэмжил зүйн газраас үзүүлж буй зарим үйлчилгээг дараах цахим мэдээллийн сангуудыг бий болгон, хэрэглээнд нэвтрүүлэхээр ажиллаж байна. Үүнд:</p> <p>Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй <b>6610</b> стандартыг нэг дороос үзэж танилцах, худалдан авах нөхцөлийг <a href="http://www.estandart.gov.mn">www.estandart.gov.mn</a> цахим сан. бүрдүүлсэн</p> <p>Хэмжил зүйн мэдээллийн сан, Сорьцын хяналтын мэдээллийн сан, Баталгаажуулалтын мэдээллийн сангийн бүртгэлийн программыг нэвтрүүлсэн.</p> <p><a href="http://www.masm.gov.mn">www.masm.gov.mn</a> цахим хуудсыг хөгжүүлж байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангасан.</p> <p>Стандарт, хэмжил зүйн газар нь бусад байгууллага, иргэд болон харьяа 21 аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн албан хаагчидтай цахимаар мэдээлэл солилцох, цахим сургалтын танхимыг бий болгон хэрэглээнд нэвтрүүлсэн.</p> <p>"Гэрэгэ Смарт пос" ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж дээрх бүртгэлийн программ, цахим хуудсыг хөгжүүлэх, сайжруулах, цахим үйлчилгээг нэвтрүүлэх, бусад үйл ажиллагааг цахимжуулах зорилготой хамтран ажилласан боловч Сангийн яамны бодлого, шийдвэр, Гэрэгэ Смарт пос" ХХК-ны нөхцөл дотоод байдлаас хамаарч цаашид хамтран ажиллах боломжгүй болсон тул ГСП 22/390 тоот гэрээ цуцлагдаж, тус арга хэмжээний хэрэгжилтийг хангахад хүндрэл үүссэн.</p> <p>- Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/197 тоот тушаалаар "Салбарын ажил, үйлчилгээ, мэдээллийн санг цахимжуулах ажлын даалгавар боловсруулах ажлын хэсэг"-ийг байгуулан салбарын нэгдсэн системийг бий болгох ажлын даалгаврыг боловсруулсан.</p>	70
11	2022 оны 10 дугаар сарын 10-ны өдөр 49 дүгээр тэмдэглэл 2022-10-10 Дугаар 2022_49 XII.5.2. Байгууллагын мэдээллийн системийг "Үндэсний дата төв" УТҮГ-ын үүлэн системд байршуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын удирдлагад даалгав.	<p>Байгууллагын цахим хуудас <a href="http://www.masm.gov.mn">www.masm.gov.mn</a>-г "Үндэсний дата төв" УТҮГ-ын үүлэн системд байршуулсан.</p> <p>Мөн сорьцын хяналтын газрын мэдээллийн сан, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн сан, баталгаажуулалтын мэдээллийн сан, стандартын мэдээллийн сан <a href="http://www.e-standard.gov.mn">www.e-standard.gov.mn</a>-ийн серверийг шилжүүлэх бэлтгэл ажлыг хангасан.</p>	70
12	X.1.3. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт	Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний	70

	<p>тусгасан зорилго, зорилтыг тухайн салбарт хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулахдаа өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах арга хэмжээ, үйл ажиллагаа, тэдгээрийн тухайн оны хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт, хүрэх (зорилтот) түвшинг урьдчилан тодорхойлж, байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгах, бусад төрийн захиргааны төв байгууллагын арга хэмжээтэй уялдуулах зорилгоор Эдийн засаг, хөгжлийн яамны саналыг тусган хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгав.</p>	<p>төлөвлөгөөнд тусгагдсан Стандарт, хэмжил зүйн газарт холбоотой заалтуудын хэрэгжилтийг хангуулах зорилгоор 2024 оны Монгол Улсыг хөгжүүлэх жилийн төлөвлөгөөнд тус заалтуудыг тусгуулах саналаа Эдийн засгийн хөгжлийн яамны төлөөлөлтэй хамтран арга хэмжээ, үйл ажиллагаа, тэдгээрийн тухайн оны хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг урьдчилан тодорхойлон боловсруулж, Эдийн засгийн хөгжлийн яаманд хүргүүлсэн.</p> <p>Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд 2025 онд шинээр хэрэгжүүлэх шаардлагатай төслийн саналыг КОЙКА-гийн төсөл боловсруулах загвар (PCP)-ын дагуу Эрдэнийн чулууны лабораторийн чадавхыг сайжруулах, Хөрсөнд шимэгч хорхой илрүүлэх молекул биологийн шинжилгээг суурин болон явуулын нөхцөлд хийх лаборатори хөгжүүлэх, Цахилгаан, урт, масс, эзлэхүүн, нягтын хэмжлийн төрлөөр хэмжлийн эталоныг хөгжүүлэх, нарийвчлалыг дээшлүүлэх, нэгж дамжуулалтыг хангах хүрээнд нийт 7 төслийг боловсруулан 2023 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн 01/561 дугаартай албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.</p> <p>- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Стандарт, хэмжил зүйн газрын нэгжийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан.</p>	
13	<p>Х.2.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж, тухайн жилд хүргэхээр тооцсон зорилтот түвшинд хүргэх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын холбогдох агентлагийн дарга нарт үүрэг болгов.</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Стандарт, хэмжил зүйн газрын нэгжийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган тайлант хугацаанд зохих арга хэмжээг авч ажилласан.</p> <p>Мөн Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд 2025 онд шинээр хэрэгжүүлэх шаардлагатай төслийн саналыг КОЙКА-гийн төсөл боловсруулах загвар (PCP)-ын дагуу уртын хэмжлийн төрлөөр эталоныг хөгжүүлэх, нарийвчлалыг дээшлүүлэх, нэгж дамжуулалтыг хангах хүрээнд төсөл боловсруулан 2023 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн 01/561 дугаартай албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.</p>	70

**Дүгнэлт:**

Стандарт, хэмжил зүйн газрын хяналтад байгаа хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн дундаж 91.12 % байна.

**Зөвлөмж:**

1. Хэрэгжилт хангалтгүй буюу удаашралтай байгаа 1, хэрэгжих шатанд байгаа 12 заалтыг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах;



### 3.2. “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилт;

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод 2 зорилтын хүрээнд 4 арга хэмжээ тусгагдсан.

№	Зорилтын дугаар	Арга хэмжээ	Хэрэгжилт (хувиар)
1.	2.5	2.5.13. Орчны эрүүл мэндийн үзүүлэлтийн шаардлага, стандарт, тохирлуудыг олон улсын стандартад ойртуулан тохируулж, шинэчилнэ.	100
2.		2.5.18. Хүнсний боловсруулах үйлдвэрүүдэд аюулын дүн шинжилгээ болон эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоо, хүнсний аюулгүй байдлын чанарын удирдлагын тогтолцоо, хүнсний хэлхээний (дамжлагуудын) хяналтын тогтолцоо, стандартыг нэвтрүүлнэ.	100
3.		2.5.19. Хүн амын хүнсний хангамж, хүртээмжийг тогтворжуулах, хүнсний сүлжээний бүх шатанд бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, хүнсний салбарын стандартуудыг олон улс, бүс нутаг, гадаад орны дэвшилтэт стандартад хүргэхэд чиглэсэн төрийн бодлогыг хэрэгжүүлнэ.	100
4.	5.3.	5.3.3. Цахим засаглалыг хөгжүүлэхэд шаардлагатай мэдээллийн технологийн салбарын стандарт, тушаал шийдвэр, дүрэм, журмыг боловсруулж, батална.	100
<b>Хэрэгжилтийн ерөнхий дүн</b>			<b>100</b>

#### Дүгнэлт:

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан 4 арга хэмжээний 2023 оны хэрэгжилт 100 хувь буюу тодорхой үр дүнд хүрсэн ба Стандарт, хэмжил зүйн газрын 2023 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус баримт бичигт тусгагдсан зорилт арга хэмжээтэй уялдуулан төлөвлөсөн байна.

#### Зөвлөмж:

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан Хүнсний боловсруулах үйлдвэрүүдэд аюулын дүн шинжилгээ болон эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоо, хүнсний аюулгүй байдлын чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлсэн аж ахуйн нэгж байгууллагыг нэмэгдүүлэх, энэ чиглэлийн баталгаажуулалт хийх хувийн хэвшлийг байгууллагыг бодлогоор дэмжлэг үзүүлэн ажиллах нь зүйтэй.

### 3.3. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт;

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд 2 зорилтын хүрээнд 2 арга хэмжээ тусгагдсан.

№	Зорилтын дугаар	Арга хэмжээ	Хэрэгжилт (хувиар)
1.	2.4	2.4.8. Хэмжил зүйн лабораторийг олон улсын жишигт хүргэсэн байна.	70
2.	4.4	4.4.4.Экспортыг дэмжих, худалдааг хөнгөвчлөхөд стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогоор дэмжлэг үзүүлнэ.	100
<b>Хэрэгжилтийн ерөнхий дүн</b>			<b>85.0</b>

**Дүгнэлт:**

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн Стандарт, хэмжил зүйн газрын хэрэгжүүлэх 2 зорилтын 2 арга хэмжээний 2023 оны хэрэгжилт 85.0 хувь буюу тодорхой үр дүнд хүрсэн байна.

**Зөвлөмж:**

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.4.8 дугаар арга хэмжээ (*Хэмжил зүйн лабораторийг олон улсын жишигт хүргэсэн байна*)-ний хэрэгжилтийг эрчимжүүлэн ажиллах нь зүйтэй.

**3.4. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт;**

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 7 арга хэмжээ тусгагдсан.

№	Зорилтын дугаар	Арга хэмжээ	Хэрэгжилт (хувиар)
	3.2.7	8. Үнэт металлын сорьцын хяналтын газрын сорьц тогтоох лаборатори байгуулж, үнэт металлыг сорьцлох, эрдэнийн чулууг тодорхойлох үйл, ажиллагааг өргөжүүлж иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. /Салбар лаборатори байгуулна.	70
5.	3.3.3	4. Мал амьтан, ургамлын гаралтай органик хүнсийг баталгаажуулан, худалдааны түнш орнуудад хүлээн зөвшөөрүүлнэ	100
6.	4.1.1	13. Стандарт, хэмжил зүйн байгууллагаас үзүүлж буй үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, мэдээллийн нэгдсэн санг бий болгоно	100
7.	4.2.9	8. Худалдаан дахь тарифын бус саад тотгорыг бууруулахад олон улсын стандартыг нутагшуулна.	100
8.		9. Бүтээн байгуулалт, мега төсөл болон экспортод чиглэсэн бараа, бүтээгдэхүүний стандартыг бий болгоно.	100
9.	4.3.16	1. Хэмжил зүйн чиглэлээр салбар лаборатори байгуулна	70
10.		2. Хэмжил зүйн салбарын эталон тоног төхөөрөмжийг шинэчилнэ	70
		<b>Хэрэгжилтийн ерөнхий дүн</b>	<b>87.14</b>

**Дүгнэлт:**

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс Стандарт, хэмжил зүйн газрын хэрэгжүүлэх 5 зорилтын 7 заалтын 2023 оны хэрэгжилт 87.14 хувь байна. Түүнчлэн Стандарт, хэмжил зүйн газрын 2023 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус баримт бичигт тусгагдсан зорилт арга хэмжээтэй уялдуулан төлөвлөсөн байна.

Эрчимжүүлэх шаардлагатай зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг 2024 оны төсөвт суулгасан байна.

**Зөвлөмж:**

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.7, 4.3.16 дугаар зорилтын хэрэгжилтийг эрчимжүүлэн ажиллах нь зүйтэй.

**Б. БАЙГУУЛЛЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТ:****3.5. Стандарт хэмжил зүйн газрын Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2023 оны биелэлт;**

Стандарт, хэмжил зүйн газрын дарга нь чиг үүргийн хүрээнд Монгол улсын Шадар сайдтай 16 зорилтын хүрээнд 76 арга хэмжээ бүхий Гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулан, хэрэгжилтийг ханган ажилласан. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 2023 оны байдлаар 96.1% байна. Үүнд:

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Гүйцэтгэлийн Хувь
<b>НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОН ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ</b>		
1.1	<b>Зорилт 1.1. Стандарт, хэмжил зүйн салбарын үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох, шинэчлэлт хийх, техникийн зохицуулалт боловсруулах, батлуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх</b>	<b>90</b>
1.1.1	Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах;	100
1.1.2	Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй нийцүүлэн холбогдох эрх зүйн баримт бичгүүдийг боловсронгуй болгох;	87,5
1.1.3	Стандарт, хэмжил зүйн талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн төслийг боловсруулах;	100
1.1.4	"Стандарт ба хөгжил" үндэсний зорилтот хөтөлбөрийн төслийг боловсруулах;	100
1.1.5	Стандарт, хэмжил зүйн салбараас үзүүлж байгаа ажил, үйлчилгээний үнэ тариф, төлбөрийн хэмжээг шинэчлэн боловсруулах, батлуулах;	90
1.1.6	"Үнэт металл, эрдэнийн чулууны жагсаалт, тэдгээрийн сорьц, чанарыг тогтоох, бүртгэх журам"-ын төслийг Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэр гаргуулах;	<b>70</b>
1.1.7	"Заавал баталгаажуулалтад хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт", "Тохирлын баталгаатай бүтээгдэхүүн, үйлчилгээг Монгол Улсын зах зээлд нийлүүлэх, улсын хилээр нэвтрүүлэх журам"-ын төслийг шинэчлэн боловсруулж, МУ-ын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэр гаргуулах /ЗГ-ын 2018 оны 291 дүгээр тогтоол/;	70
1.1.8	Хэмжил зүй, сорьцын хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх, Улсын байцаагчийн эрх зүйн баримт бичгийн маягыг шинэчлэх;	100
1.1.9	Эрдэнийн чулууны лабораторийг итгэмжлэлд хамруулах, Хэмжил зүйн хүрээлэнгийн эталоны лаборатори болон Нийслэлийн төв лабораторийг давтан итгэмжлэлд хамруулах;	50
1.2	<b>Зорилт 1.2. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах.</b>	<b>100</b>
1.2.1	Бүтээн байгуулалт, мега төсөл болон экспортод чиглэсэн бараа, бүтээгдэхүүний стандартыг бий болгох	100
1.3	<b>Зорилт 1.3. Үндэсний стандартад олон улсын стандартын эзлэх хувийг нэмэгдүүлэх.</b>	<b>100</b>
1.3.1	Үндэсний стандартыг батлах, хүчингүй болгох;	100
1.3.2	Үндэсний стандартын шинжлэх ухаан, техникийн түвшнийг тогтоох үзлэг хийх;	100
1.4	<b>Зорилт 1.4. Хэмжил зүйн салбарт шаардлагатай эталон бий болгох.</b>	<b>85</b>
1.4.1	Улсын болон ажлын эталоныг шинээр болон шинэчлэн бий болгох, хөгжүүлэх төсөл боловсруулах;	70
1.4.2	Хийн тоолуур шалгах ажлын эталон бий болгох;	70

1.4.3	Аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсүүдийг эталон тоног төхөөрөмжөөр хангах;	100
1.4.4	Улсын хэмжээнд хэмжих хэрэгсэл, хэмжүүрийн тооллого хийх ажлыг зохион байгуулах;	100
<b>1.5</b>	<b>Зорилт 1.5. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах ажлыг зохион байгуулах.</b>	<b>100</b>
1.5.1	Эталон болон хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга хийх, нэгж дамжуулалтыг хангах ажлыг зохион байгуулах;	100
1.5.2	Хэмжих хэрэгслийн загварыг турших, батлах, хэмжил зүйн мэдээллийн санд бүртгэх;	100
1.5.3	Хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын чадавхыг үнэлэх, бүртгэх;	100
1.5.4	Хэмжих хэрэгслийг шалгаж баталгаажуулах;	100
1.5.5	Хэмжил зүйн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, мэдээллийн санг бүрдүүлэх;	100
1.5.6	Эталоны хэмжил, шалгалт тохируулгын чадавхаа олон улсад хүлээн зөвшөөрүүлэх үнэлгээнд хамрагдах;	100
1.5.7	Хэмжил зүйн олон улсын лаборатори хоорондын харьцуулалтад оролцох;	100
1.5.8	Хэмжил зүйн Олон Улсын хурал зохион байгуулах;	100
<b>1.6</b>	<b>Зорилт 1.6. Хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүнийг тохирлын үнэлгээнд хамруулж, нэр төрлийг нэмэгдүүлэх.</b>	<b>100</b>
1.6.1	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд баталгаажуулалтын зарим үйл ажиллагааг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх;	100
1.6.2	Заавал баталгаажуулалтад хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээнд баталгаажуулалт хийх байгууллагыг шинээр бий болгоход дэмжлэг үзүүлэх;	100
1.6.3	Заавал баталгаажуулалтад хамрагдах бүтээгдэхүүн, үйлчилгээг баталгаажуулах;	100
1.6.4	Олон улсын менежментийн тогтолцооны ISO 9001, ISO 14001, ISO 45001, ISO 50001, ISO 22000, HACCP стандартыг хэрэгжүүлсэн ААНБ-уудад анхдагч болон давтан аудит явуулж, гэрчилгээжүүлэх;	100
1.6.5	Салбарын хэмжээнд заавал баталгаажуулалтад хамрагдах бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх;	100
1.6.6	Бүтээгдэхүүний баталгаажуулалтын итгэмжлэлийн хүрээг органик хүнс, халал баталгаажуулалтын төрлөөр өргөтгөх бэлтгэл ажлыг ханган, гэрчилгээ олгох, итгэмжлэгдэх;	100
1.6.7	MNS/IEC 17065, MNS ISO 17021 стандартын шаардлагыг үргэлжлүүлэн хангаж, хугацаа сунгуулах итгэмжлэлд хамрагдах;	100
1.6.8	Мал амьтан, ургамлын гаралтай органик хүнсийг баталгаажуулах;	100
1.6.9	Чанарын дэд бүтцийн бүрэлдэхүүн, оролцогч ба сонирхогч талуудад чиглэсэн Дэлхийн чанарын өдрийг тэмдэглэх, Үндэсний чанарын шагнал олгох арга хэмжээг зохион байгуулах;	100
<b>1.7</b>	<b>Зорилт 1.7. Үнэт металлын сорьцын хяналтын тогтолцоог бэхжүүлэх.</b>	<b>90</b>
1.7.1	Сорьцын баталгааны тэмдэг (клейм)-ийг ISO 9202:2019 стандартад нийцүүлэн шинэчлэх;	70
1.7.2	Үнэт металлын сорьцын хяналт шалгалтыг зохион байгуулах, худалдаа эрхлэгч болон хэрэглэгчдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх;	100
1.7.3	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн олборлосон үнэт металлыг хайлж гулдмайлах, дугаарлах, хайлалтын акт бичих үйлчилгээ үзүүлэх;	100
<b>1.8</b>	<b>Зорилт 1.8. Хүнс болон хүнсний бус бүтээгдэхүүний дээжид үндэсний болон олон улсын батлагдсан арга, аргачлалыг ашиглан шинжилгээг хийж гүйцэтгэх.</b>	<b>100</b>
1.8.1	Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн дээжид үндэсний болон олон улсын батлагдсан арга аргачлалын дагуу шинжилгээ хийх;	100
1.8.2	Итгэмжлэгдсэн төрийн болон хувийн өмчит лабораториудыг мэргэжил, арга зүйгээр хангах, сургалт зохион байгуулах;	100

1.8.3	Итгэмжлэгдсэн төрийн, орон нутгийн болон хувийн өмчит лабораториудын шинжилгээний үр чадварыг үнэлэх хөтөлбөрийг “MNS ISO 17043:2010. Тохирлын үнэлгээ-Ур чадварын сорилтод тавих ерөнхий шаардлага” стандартын дагуу зохион байгуулах, лабораторийн мэдээллийн цахим санг өргөжүүлэх (ХБАБХТХ-ийн 15.2.5);	100
1.8.4	Лабораторийн үйл ажиллагааг “MNS/ISO IEC 17025:2018. Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторид тавигдах ерөнхий шаардлага стандартад нийцүүлж, итгэмжлэлийн давтан үнэлгээнд хамрагдах;	100
1.8.5	Шинжилгээний үр дүнгийн мэдээллийн сан бүрдүүлэх /ХБАБХТХ-ийн 15.2.2/;	100
1.8.6	Шинжилгээний арга аргачлал нэвтрүүлэх, туршилтын шинжилгээг хийж гүйцэтгэх, санал өгөх, нэмэлт өөрчлөлт оруулах / ХБАБХТХ-ийн 15.2.5/;	100
<b>ХОЁРДУГААР ХЭСЭГ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ</b>		
<b>2.1</b>	<b>Зорилт 2.1. Стандарт, хэмжил зүйн газраас үзүүлж буй үйлчилгээг цахимжуулах.</b>	<b>70</b>
2.1.1	Төрийн үйлчилгээг технологийн дэвшилд суурилсан, цахим хэлбэрт шилжүүлэх, байгууллагын веб сайтын тасралтгүй хэвийн ажиллагааг ханган ажиллах, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлж буй төрийн үйлчилгээг амар хялбар, ил тод, нээлттэй, түргэн шуурхай үзүүлэх;	70
2.1.2	Стандарт, хэмжил зүйн газраас үзүүлж буй үйлчилгээг цахимжуулах, мэдээллийн санг хөгжүүлэх;	70
2.1.3	Стандарт, хэмжил зүйн газраас “E-Mongolia” цахим сангаар олгож буй үйлчилгээ, лавлагааны тоог нэмэгдүүлэх;	70
2.1.4	Эрдэнийн чулууны гэрчилгээтэй бүтээгдэхүүний мэдээллийн цахим санг бий болгох;	70
2.1.5	Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын үнэт металл хайлуулах захиалгыг цахимаар хүлээн авах, бүртгэх үйлчилгээ үзүүлэх;	70
2.1.6	Алтны сорьц тогтоосон сорилтын дүнг арилжааны банкнуудад цахимаар хүргүүлэх үйлчилгээ үзүүлэх;	70
<b>ГУРАВДУГААР ХЭСЭГ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ</b>		
<b>3.1</b>	<b>Зорилт 3.1. Стандарт, хэмжил зүйн салбарын орлогыг нэмэгдүүлэх</b>	<b>100</b>
3.1.1	Үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, баталгаажуулах, тайлагнах;	100
3.1.2	Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах, холбогдох газарт хүргүүлэх, Үндэсний аудитын газраар хянуулж, баталгаажуулах;	100
<b>3.2</b>	<b>Зорилт 3.2. Стандарт, хэмжил зүйн салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх.</b>	<b>100</b>
3.2.1	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ 2024 оны төсвийн төсөлд салбараас санал авч, боловсруулан, холбогдох байгууллагад хүргүүлэх, батлуулах;	100
3.2.2	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулах;	100
<b>3.3</b>	<b>Зорилт 3.3. Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх.</b>	<b>100</b>
3.3.1	Олон Улсын Цахилгаан техникийн Хороо (IEC)-н дахь Стандарт, хэмжил зүйн газрын гишүүнчлэлийн статусыг ахиулах хүсэлтийг хүргүүлэх;	100
3.3.2	Хоёр талт хамтын ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх хүрээнд хамтарсан төсөл хэрэгжүүлэх;	100
3.3.3	Хоёр талт хамтын ажиллагааг хөгжүүлэх хүрээнд шинэ байгууллагатай санамж бичиг, үйл ажиллагааны төлөвлөгөө, гэрээ байгуулах;	100
3.3.4	Гадаад хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд байгуулсан үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах;	100
3.3.5	Ази Номхон Далайн Хэмжил зүйн Хөтөлбөрийн 2023 оны эхний хагас жилийн уулзалтыг Монгол Улсад зохион байгуулах;	100

<b>3.4</b>	<b>Зорилт 3.4. Салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.</b>	<b>100</b>
3.4.1	Стандарт, хэмжил зүйн газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд болон аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсүүдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, арга зүйн зөвлөмж өгөх;	100
<b>3.5</b>	<b>Зорилт 3.5. Төрийн захиргааны удирдлага зохион байгуулалтыг хангах.</b>	<b>100</b>
3.5.1	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийг Стандарт, хэмжил зүйн газрын дэргэд байгуулах;	100
3.5.2	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд заасан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	100
3.5.3	Тэмдэглэлт ой, түүхэн өдрийг тохиолдуулан ажилтан, албан хаагчдыг төрийн дээд одон медаль, салбарын шагнал, бусад шагналд тодорхойлох;	100
3.5.4	Стандарт, хэмжил зүйн салбарын удирдах ажилтны зөвлөгөөн зохион байгуулах;	100
<b>3.6</b>	<b>Зорилт 3.6. Стандарт, хэмжил зүйн салбарын мэргэжилтэн бэлтгэх, чадавхжуулах тогтолцоог бүрдүүлэх.</b>	<b>100</b>
3.6.1	Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх сургалтын 2023 оны төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангах;	100
3.6.2	Стандарт, хэмжил зүйн салбарын ажилтан, албан хаагчдын Нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, Сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжилтийг хангаж ажиллах;	100
3.6.3	Стандартчилал, тохирлын үнэлгээ, баталгаажуулалтын чиглэлээр мэргэжилтний ур чадварыг дээшлүүлэх, гадаад сургалтад хамруулах;	100
3.6.4	Гадаад сургалт, хурал, семинар, уулзалтыг зохион байгуулах, албан хаагчдыг оролцуулахад дэмжлэг үзүүлэн ажиллах;	100
3.6.5	Стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжил зүйн чиглэлээр төлөвлөгөөт, захиалгат, нэмэлт сургалтыг зохион байгуулах;	100
<b>3.7</b>	<b>Зорилт 3.7. Төрийн үйлчилгээг ил тод, хурдан шуурхай, чанартай, хүртээмжтэй болгох.</b>	<b>100</b>
3.7.1	Стандарт, хэмжил зүйн салбарын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, мэдээлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах, “Стандарт, хэмжил зүй” сэтгүүлийг тогтмол эрхлэн явуулах;	100
3.7.2	Стандарт, хэмжил зүйн талаарх олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх чиглэлээр сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах	100
3.7.3	“Стандарт ба Хөгжил” хэлэлцүүлэг зохион байгуулах /21 аймаг, төр, хувийн хэвшил/;	100
3.7.4	Нээлттэй хаалганы өдөрлөг арга хэмжээг зохион байгуулахад оролцож, дэмжлэг үзүүлэх;	100
3.7.5	Дэлхийн хэмжил зүйн өдөр, Дэлхийн Стандартын өдрийг тохиолдуулан үйл ажиллагаа, хэлэлцүүлэг зохион байгуулах;	100
3.7.6	Говьсүмбэр аймагт шинээр Стандарт, хэмжил зүйн хэлтэс бий болгох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;	100
3.7.7	Аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн ажиллах орчныг сайжруулах, материаллаг бааз суурийг нэмэгдүүлэх;	100
3.7.8	Ажилтан, албан хаагчдыг идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх, эрүүл мэндийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах;	100
3.7.9	Стандарт, хэмжил зүйн салбар байгуулагдсаны 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөө боловсруулах, шийдвэр гаргуулах, хэрэгжүүлэх;	100
	<b>ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ</b>	<b>96,1</b>

**3.6. Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2022 оны А/102 дугаар тушаалаар батлагдсан Стандарт, хэмжил зүйн салбарын албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт;**

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 4 дүгээр хавсралт

**СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ (2023 он)**

№	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар	Хэрэгжилт
Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх							
1.	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	1.1.	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо:	-	42		100%
		Үүнээс	Ажлын байран дахь сургалт	-	5		
			Мэргэшүүлэх сургалт	-	5		
			Туршлага солилцох арга хэмжээ	-	-		
			Бусад	-	-		
		1.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	-	180		
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	-	110		
			Эрэгтэй албан хаагч	-	70		
			Удирдах албан тушаалтан	-	14		
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-	166		
1.3.	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	90-ээс дээш	95,2%				
2.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	2.1.	Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо	-	50		100%
		2.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	-	176		
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	-	104		
			Эрэгтэй албан хаагч	-	72		
			Удирдах албан тушаалтан	-	69		
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-	107		

		2.3.	Гадаад сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	20-оос дээш	56,5		
3.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	3.1.	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	-	6,058 сая,төг	2023 оны байдлаар байхгүй.	100%
		3.2.	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь	15-аас доош	18,5%		
Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах.							
4.	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	4.1.	Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь	-	2,353,347 сая,төг	Цалин болон үнэлгээний урамшуулал	100%
		4.2.	Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян.төг)	-	424,551 сая,төг		
5.	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	5.1.	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж)	80-аас дээш	90%		100%
6.	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	6.1.	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (Жилд)	1-ээс дээш	-		70%
		6.2.	Албан хаагчдын хамрагдалт	90-ээс дээш	-		
7.	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	7.1.	Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	-	1,031,282 сая,төг	Албан хаагчдын ур чадварын болон зэрэг дэвийн нэмэгдэл, унаа хоолны мөнгө	100%
Хэрэгжилт							95,7%

## В. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮЗҮҮЛЭЛТ:

### 3.7. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ;

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9 дүгээр хавсралтын дагуу Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг 5 ангиллын 46 шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэв.



Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийг тайлан, гадагш чиглэсэн сургалт мэдээлэл, цахим хуудас, мэдээллийн самбарын хөтлөлт зэргийг харгалзан үзэж 99,4% буюу 4.97 оноогоор үнэлэв.

№	Шалгуур үзүүлэлт	Заалтын тоо	Биелэлт
1	Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	10	100,0%
2	Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал	6	100,0%
3	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	15	98%
4	Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	2	100%
5	Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	13	100%
	Нийт үнэлгээ	48	99,4%

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэн үйл ажиллагааны, хүний нөөцийн, төсөв санхүүгийн болон төрийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах мэдээллийг байгууллагын цахим хуудасны “ил тод” цэсэд байршуулан мэдээлсэн.

Шилэн дансны тухай хууль, журамд заасан мэдээллийг байгууллагын цахим хуудсаар мэдээлэн, үйл ажиллагаатай холбоотой тодруулга өгөх утасны дугаар, цахим хаягийг байршуулан, ил тод байдлыг ханган ажилласан.

Байгууллагын эрхлэн явуулдаг үйл ажиллагааны чиглэлээр зөвхөн хууль тогтоомжид заасан төлбөр хураамжийг үйлчлүүлэгчээс авч байгаа бөгөөд төлбөр хураамжийн хэмжээг мэдээллийн самбар, цахим хэлбэрээр мэдээлж байна.

Түүнчлэн Стандарт, хэмжил зүйн газар нь 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар нийт 1496 мэдээ мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтлэгдэж, цацагдсан байна. Үүнд:

- Masm.gov.mn сайтад мэдээ – 386;
- Телевизийн зочны цагт нэвтрүүлэг – 10;
- Телевизийн мэдээ – 282;
- Бусад сайт – 15;
- Радио мэдээ, радио зөвлөмж, радио атлас-787;
- 100 чухал сэдэв нэвтрүүлэг - 1;
- “Юманд хэмжээ бий” нөлөөллийн аян – 15.

### 3.8. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ;

ХШУДАГ-аас Стандарт, хэмжил зүйн газрын www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулсан мэдээлэлд хяналт-шинжилгээ хийхэд нийт 159 мэдээлэл оруулахаас хугацаандаа оруулсан 145 мэдээлэл, хугацаа хоцроосон 1, хугацаа болоогүй 13 мэдээлэл байна. Түүнчлэн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын нийт 96 гүйлгээ байршуулснаас зарлагын 66, орлогын 30 байна. Шилэн дансны хөтлөлтийн 90% буюу 4.5 оноогоор үнэлэв.

### 3.9. Шударга байдлын түвшний үнэлгээ;

Авлигатай тэмцэх газраас 2015 оноос эхлэн төрийн байгууллагын шударга байдлын түвшинд “Шударга байдлын үнэлгээ”-ний судалгааг зохион байгуулж <https://iaas.mn/> цахим санд байршуулсан байдаг. 2023 оны үнэлгээ хийгээгүй учраас 2022 оны судалгааны дүнгээр уг үзүүлэлтийн тооцов. Үүнд:

Судалгаанаас үзэхэд Стандарт, хэмжил зүйн газрын шударга байдлын үнэлгээ нь 2021 онд 77.1 оноотой, 2022 онд 79.3 оноотой буюу 2021 онтой харьцуулахад 2.1 пунктээр өссөн, улсын дунджаас 5.4 пунктээр дээш үнэлэгдсэн байна.

Стандарт хэмжил зүйн газрын даргаар Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 20 арга хэмжээ төлөвлөнө хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тайлангийн хугацаанд авлига, ашиг сонирхлын зөрчил гаргасан албан хаагч байхгүй ажиллаж байна.

### 3.10. Хэрэглэгчийн үнэлгээ;

Стандарт, хэмжил зүйн газар нь агентлагийн даргын 2015 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан СХЗГ-ББ-09 (01):2015 “Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээний журам”-ын дагуу хэрэглэгчийн үнэлгээг хийж байна.

2023 онд Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогын газар 110 техникийн хороодын гишүүдээс, Бүтээгдэхүүн, тогтолцооны баталгаажуулалтын газар 82, Хэмжил зүйн бодлогын газар 54, Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтын газар 135, Сорьцын хяналтын газар 41, Стандартын мэдээлэл, лавлагаа, сургалтын төв нь 300 нийт 722 хэрэглэгч, үйлчлүүлэгч, техникийн хороодын гишүүдээс 5-10 асуумж бүхий сэтгэл ханамжийн судалгааг Google form ашиглан онлайн аар болон цаасаар авч Чанарын хорооны гишүүд нэгтгэн дүн шинжилгээ хийн ажилласан. Тухайлбал:

Хэрэглэгчийн үнэлгээний хувьд Хэмжил зүйн бодлогын газрын 93.1%, Бүтээгдэхүүн тогтолцооны баталгаажуулалтын газрын хүссэн мэдээллийг бүрэн гүйцэт авдаг эсэхэд 77%, үйл ажиллагаатай холбогдолтой бусад асуумж дээр 93.8% үнэлэгдсэн бол Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтын газар нь 85.2%, Сорьцын хяналтын газар нь 90.5% үнэлэгдсэн байна.

Стандарт, хэмжил зүйн газар 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 318 өргөдлийг хүлээн авч хуулийн хугацаанд 308 өргөдлийг шийдвэрлэсэн ба 10 өргөдлийг судалж байна.

### Дөрөв. Дүгнэлт, Зөвлөмж

Стандарт, хэмжил зүйн газрын 2023 онд гаргасан амжилтуудаас дурдвал:

1. 2023 онд эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлын хүрээнд доорх баримт бичгүүдийг төслийг боловсруулж Шадар сайдын ажлын албанд хүргүүлсэн. Үүнд:
  - ✓ Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл;
  - ✓ Стандартчилал, хэмжил зүйн талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн төсөл;
  - ✓ “Стандарт ба хөгжил” үндэсний зорилтот хөтөлбөрийн төсөл;
  - ✓ Стандарт, хэмжил зүйн салбараас үзүүлж байгаа ажил, үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоох аргачлал;
2. Ази, Номхон далайн бүс нутгийн хэмжил зүйн хөтөлбөр (APMP)-ийн хагас жилийн уулзалтыг 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдрөөс 16-ны өдрүүдэд Улаанбаатар хотод амжилттай зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээнд Япон, Солонгос, Хятад, Герман, Фижи, АНУ, Австрали, Монгол, Тайланд, Тайван, Вьетнам, Шинэ Зеланд, Малайз, Энэтхэг, Филиппин, Индонез, Өмнөд африк, Непал, Кирибати, Шри-ланка зэрэг 20 гаруй орны Хэмжил зүйн байгууллагын гадаадын 52 төлөөлөл танхимаар, 20 гаруй төлөөлөгчид цахимаар оролцлоо.
3. Экспортыг дэмжих төслийн дэмжлэгтэйгээр Олон улсын органик хөдөө аж ахуй нүүдлийн холбоо (IFOAM)-ны итгэмжлэлийн байгууллага (IOAS)-аар органик

бүтээгдэхүүний баталгаажуулалтыг итгэмжлүүлэх, Булангийн орнуудын магадлан итгэмжлэлийн төв (GAC) байгууллагаар ХАЛАЛ бүтээгдэхүүний баталгаажуулалтыг итгэмжлүүлэх ажлыг хийж байна.

4. Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр:

- Бүгд Найрамдах Турк Улсын Стандартын хүрээлэн (TSE)-тэй стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжил зүй, сургалтын чиглэлээр 2023-2027 онд хамтран ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөө;
- Бүгд Найрамдах Турк Улсын Халал итгэмжлэлийн агентлагтай Харилцан ойлголцлын санамж бичиг;
- Бүгд Найрамдах Турк Улсын Шинжлэх ухаан, технологийн судалгааны зөвлөл (TUBITAK)-тэй Харилцан ойлголцлын санамж бичиг;
- ОХУ-ын Холбооны техникийн зохицуулалт, хэмжил зүйн агентлаг (ROSSTANDART)-тай 2023-2025 онд Хамтран ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөө;
- Канад улсын Стандартчиллын зөвлөл (SCC)-тэй Хамтран ажиллах хэлэлцээр, хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө;
- БНСУ-ын Стандарт ба эрдэм шинжилгээний судалгааны хүрээлэн (KRIS) -тэй Харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулсан.

5. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 1496 мэдээ мэдээлэл нийтлэгдэж, үйл ажиллагааг сурталчилсан байна. Үүнд:

- Masm.gov.mn сайтад мэдээ – 386;
- Телевизийн зочны цагт нэвтрүүлэг – 10;
- Телевизийн мэдээ – 282;
- Бусад сайт – 15;
- Радио мэдээ, радио зөвлөмж, радио атлас-787;
- 100 чухал сэдэв нэвтрүүлэг – 1;
- “Юманд хэмжээ бий” аян – 15.

**Дүгнэлт:**

2023 онд Стандарт, хэмжил зүйн газрын үйл ажиллагааг нь эрх зүйн орчныг боловсронгуй болгох, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, Стандарт хэмжил зүйн салбарын үйл ажиллагааг сурталчлах, стандартын талаар байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлэх зэрэгт онцгой анхаарч ажилласан байна.

Стандарт, хэмжил зүйн газрын 2023 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг Монгол Улсын бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээтэй уялдуулан төлөвлөсөн.

Түүнчлэн төсвийн ерөнхийлөн захирагчаас эрх шилжин ирсэн хөрөнгө мөнгийг зарцуулах, хуваарилах, хянах ажлыг холбогдох хуулийн дагуу хийж, хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэн 49 албан хаагчдын ур чадварын нэмэгдлийг нэмэх, 79 албан хаагчид зэрэг дэвийг нэмэгдүүлэх болон шинээр олгох шийдвэрийг Шадар сайдаар гаргуулсан байна.

Стандарт, хэмжил зүйн газрын 2023 оны үйл ажиллагааны үнэлгээний дүн 92.2% буюу ерөнхий үнэлгээ нь 4.61 оноотой дүгнэгдлээ.

**Зөвлөмж:**

1. Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг болон СХЗГ-ын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнөөс хугацаандаа хэрэгжээгүй болон дутуу хэрэгжилттэй зорилт, арга

хэмжээг 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх, нэгжийн дарга нь хяналт тавих;

2. Байгууллагын [masm.gov.mn](http://masm.gov.mn) цахим хуудсыг хөгжүүлэх, үйл ажиллагааг цахимжуулах ажлыг эрчимжүүлэх;

ТАНИЛЦСАН:

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.УУГАНБАЯР

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД  
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА

С.БАТБААТАР

2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр